



ХӨСӨГ ТРЕЙД

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2023 оны 04 сар 20 өдөр

№ 07

Улаанбаатар хот

ХЭЛЭЛЦСЭН НЬ:

“ХӨСӨГ ТРЕЙД” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн 2023 оны ээлжит хурлыг 2023 оны 04-р сарын 20-ний өдрийн 11 цаг 30 минутад Улаанбаатар хот, Сүхбаатар дүүргийн 8-р хороо, Сэнтрал тауэр, 902 тоот Хурлын танхимд болов.

Хуралд :

С.Жавзан-Орлом 51,974 ширхэг хувьцааны саналаар /өөрийн биеэр/

Г.Маргад 53,916 ширхэг хувьцааны саналаар /өөрийн биеэр/

Ж.Энхтунгалаг 1 ширхэг хувьцааны саналаар /өөрийн биеэр/

Д.Бадам 88,118 ширхэг хувьцааны саналаар /саналын хуудсаар/

Эй Ди Эм Ди ХХК 96,357 ширхэг хувьцааны саналаар, Гүйцэтгэх захирал Ж.Гантогтох /өөрийн биеэр/ тус тус оролцож нийт 290,366 ширхэг хувьцаа буюу нийт гаргасан хувьцааны 98.2% хувийг эзэмшигчид хуралд оролцлоо.

Хурлыг компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга Сайнжаргалын Болор удирдав.
Хурлаар:

1. Компанийн 2022 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаар ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг батлах;
2. Ногдол ашиг хуваарилахгүй талаар ТУЗ гаргасан шийдвэрийг танилцуулах;
3. Компанийн одоо эрхэлж байгаа үйл ажиллагааны чиглэлүүдийг хасах;
4. Үл хөдлөх хөрөнгийн түрээсийн үйл ажиллагаа эрхлэх чиглэлийг дүрэмд нэмэх;
5. Компанийн дүрмийн шинэчилсэн найруулгыг батлах тухай тус тус хэлэлцэв.

Хурлын дарга С.Болор: Тооллогын комисс ирцээ гаргасан бол танилцуулъя. Хурал хуульд заасан ирцийн шаардлага хангасан хүчин төгөлдөр бол хурлаа эхэлье.

Тооллогын комиссын дарга Б.Гэрэлмаа хурлын ирцийг танилцуулан, Тооллогын комиссын тогтоолыг уншиж танилцуулав. Тооллогын комиссын тогтоолоос үзэхэд хурлын ирц 98.2% хувьтай байгаа тул Монголын Улсын Компанийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1-д заасны дагуу хурлын ирцийг хүчин төгөлдөрт тооцож, хурлыг эхлүүлэх зөвшөөрлийг Хурлын даргад өгөв.

Хурал 12 цаг 00 минутад эхлэв.

СОНССОН НЬ :

Хурлын дарга С.Болор: Бүгдэд нь энэ өдрийн мэндийг хүргэе. Ингээд Хөсөг трейд компанийн Хувьцаа эзэмшигчдийн 2023 оны ээлжит хурлаа эхэлье. Энэ удаагийн хурлаар дараах дэгийн дагуу асуудлыг хэлэлцэнэ. Ингээд хурлын дэг, хэлэлцэх асуудлыг уншиж танилцуулъя.

1. Компанийн 2022 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг танилцуулна;
2. Компанийн 2022 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаар ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэн батална;
3. Ногдол ашиг хуваарилахгүй талаар ТУЗ-ийн гаргасан шийдвэрийг танилцуулна;
4. Компанийн үйл ажиллагааны чиглэлийг өөрчлөх, үл хөдлөх хөрөнгийн түрээсийн үйл ажиллагаа эрхлэх чиглэлийг нэмэх талаар танилцуулна;
5. Компанийн дүрмийн шинэчилсэн найруулгыг танилцуулна;
6. Хурлаас гарах шийдвэрийн төсөлтэй холбогдсон асуулт, хариултыг явуулна;
7. Тооллогын комисс саналын хуудас бөглөх заавар танилцуулж, саналын хуудсаар санал авна;
8. Тооллогын комисс санал хураалтын дүнг танилцуулна;
9. Хурлаас гарах шийдвэр, тогтоолыг танилцуулна.

Хэлэлцэх асуудлын дагуу Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга Б.Анхбаяр 2022 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг уншиж танилцуулав.

Хурлын дарга С.Болор: Одоо компанийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-н дүгнэлт болон ногдол ашиг хуваарилахгүй талаар ТУЗ-н гаргасан шийдвэрийг тус тус уншиж танилцуулъя.

Хурлын дарга ТУЗ-н дүгнэлт болон ногдол ашиг хуваарилахгүй талаар ТУЗ-ийн гаргасан шийдвэрийг тус бүр уншиж танилцуулав.

Хурлын дарга С.Болор: Дараагийн хэлэлцэх асуудлаа танилцуулъя. Компанийн үйл ажиллагааны чиглэлийг өөрчлөх, үл хөдлөх хөрөнгийн түрээсийн үйл ажиллагаа эрхлэх чиглэлийг нэмэх талаар болон компанийн дүрэмд орсон өөрчлөлтүүдийг нэг бүрчлэн танилцуулаад явъя.

Хурлын дарга компанийн үйл ажиллагааны чиглэлийг өөрчлөх, үл хөдлөх хөрөнгийн түрээсийн үйл ажиллагаа эрхлэх чиглэлийг нэмэх талаар танилцуулж тайлбар хийн, компанийн дүрмийн шинэчилсэн найруулгыг уншиж танилцуулав.

Хурлын дарга С.Болор: За ингээд өнөөдрийн хурлаар танилцуулах зүйлс энэ хүрээд дуусаж байна. Одоо дурдсан асуудлуудтай холбоотой хувьцаа эзэмшигчдээс асуух асуулт байвал дараалал аваад асууя.

Хувьцаа эзэмшигч Ж.Энхтунгалаг: Хөсөг трейд өмнө нь ч мөн түрээсийн үйл ажиллагаа явуулж байсан биз дээ? Одоо түрээсийн үйл ажиллагаа эрхлэх чиглэлийг тусгайлан нэмж байгаа нь ямар учиртай билээ?

Хурлын дарга С.Болор: Өмнө нь автотээврийн үндэсний төв манай газар дээр байсан тул засвар үйлчилгээ, дугаар олгох, банк зэрэг дагалдах аж ахуйн нэгжүүдэд түрээслүүлдэг байсан. Мөн цайны газар, оюутны дотуур байр зэргээр түрээслүүлдэг байсан. Өөрөөр хэлбэл олон жижиг түрээслэгч нартай байсан бөгөөд энэ компанид ирээдүйд үр ашиггүй, зардал ихтэй байсан. Тухайлбал, засвар арчлалт, харуул хамгаалалт, цэвэрлэгээ үйлчилгээ гэх мэт. Харин одоо олон улсын экспортын үйлдвэр барьж байгаа бөгөөд тухайн үйлдвэрлэгчид газар, үл хөдлөхөө түрээслүүлж түүнээс

орлогоо олж явах боломжтой болсон тул үндсэн үйл ажиллагааны чиглэл түрээс болж байгаатай холбоотой юм.

Хувьцаа эзэмшигч Ж.Энхтунгалаг: Ногдол ашиг тараахгүй шалтгаан нь алдагдалтай хамааралтай гэсэн үү?

Хурлын дарга С.Болор: Энэ жил дэд бүтцийн ажлууд нэлээд хийсэн. Тиймээс тийшээ хөрөнгө оруулалтууд орсон байгаа.

Хувьцаа эзэмшигч Ж.Энхтунгалаг: Одоо нийт хэдэн хувьцаа эзэмшигч байгаа вэ?

Хурлын дарга С.Болор: 2023 оны 03 сарын 31-ний өдрийн байдлаар нийт 84 хувьцаа эзэмшигч байна. Үүнээс 5 хувьцаа эзэмшигч нийлээд 292,703 ширхэг буюу нийт хувьцааны 98.9 хувийг эзэмшиж байгаа.

Хурлын дарга С.Болор: Бусад хувьцаа эзэмшигчдэд асууж тодруулах зүйл байгаа юу?

Хувьцаа эзэмшигч Ж.Гантогтох: Ногдол ашиг тараахгүй тухай ТУЗ-н шийдвэр болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-н дүгнэлттэй танилцлаа. Шийдвэр, дүгнэлтүүдийг зөв гэж бодож байна. Асуулт алга байна.

Хувьцаа эзэмшигч Г.Маргад: Миний хувьд саналгүй байна. Баярлалаа.

Хувьцаа эзэмшигч С.Жавзан-Орлом: Надад асуулт байна. Одоо тэгэхээр автотээвэртэй холбоотой үзлэг оношилгооны газрууд хөсөг дээр байхгүй болсон гэж ойлгох уу?

ТУЗ-н нарийн бичгийн дарга Б.Анхбаяр: Тиймээ, одоо зөвхөн барилгын ажил хийгдэж байгаа. Ийнхүү барилгын ажил хийхтэй холбоотой тухайн компанид агуулах байр саваа түрээслүүлээд явж байгаа.

Хурлын дарга С.Болор: За хувьцаа эзэмшигч нарт өөр санал байхгүй бол хурлын дэгийн дагуу санал хураалт явуулъя. Саналаа саналын хуудсаар өгнө. Тооллогын комиссын дарга та бүхэнд саналын хуудсыг хэрхэн бөглөх талаар заавар өгнө.

Хурал 20 минут завсарлаад тооллогын комисс саналаа хурааж, дүнгээ гарган уншиж танилцуулав.

Тооллогын комиссын дарга Б.Гэрэлмаа: Хувьцаа эзэмшигчдийн өгсөн саналын хуудасны дагуу дараах дүн гарч байна.

1. Компанийн 2022 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаар ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг зөвшөөрсөн саналын тоо 290,366 ширхэг буюу хуралд оролцсон хувьцаа эзэмшигчдийн 100 хувийн саналаар зөвшөөрсөн.
2. Компанийн одоо эрхэлж байгаа үйл ажиллагааны чиглэлүүдийг хасахыг зөвшөөрсөн саналын тоо 290,366 ширхэг буюу хуралд оролцсон хувьцаа эзэмшигчдийн 100 хувийн саналаар зөвшөөрсөн.
3. Үл хөдлөх хөрөнгийн түрээсийн үйл ажиллагаа эрхлэх чиглэлийг дүрэмд нэмэхийг зөвшөөрсөн саналын тоо 290,366 ширхэг буюу хуралд оролцсон хувьцаа эзэмшигчдийн 100 хувийн саналаар зөвшөөрсөн.
4. Компанийн дүрмийн шинэчилсэн найруулгыг батлахыг зөвшөөрсөн саналын тоо 290,366 ширхэг буюу хуралд оролцсон хувьцаа эзэмшигчдийн 100 хувийн саналаар зөвшөөрсөн.

Хувьцаа эзэмшигчдийн хурлаас гарах тогтоолын төслийг хурлын дарга уншиж танилцуулан, хурлын материалыг холбогдох хууль тогтоомжийн дагуу бүртгүүлэхийг дурдав.

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

1. Компанийн 2022 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг баталсугай.
2. Компани 2022 онд ногдол ашиг хуваарилахгүй байхаар шийдвэрлэсэн төлөөлөн удирдах зөвлөлийн тогтоолыг танилцуулсныг дурдсугай.
3. Компанийн одоо эрхэлж байгаа “авто замаар ачаа тээвэрлэх үйлчилгээ”, “автомашины засвар үйлчилгээ”, “гадаад дотоод худалдаа”, “зочид буудал, цайны газар” гэх үйл ажиллагааны чиглэлүүдийг хасаж “үл хөдлөх хөрөнгийн түрээсийн үйл ажиллагаа эрхлэх” чиглэлийг дүрэмд нэмснийг дурдсугай.
4. “Хөсөг трейд” ХК-ийн дүрмийг шийдвэрийн хавсралтаар шинэчлэн баталсугай.
5. Компанийн дүрмийн шинэчилсэн найруулга батлагдсантай холбоотойгоор Улсын бүртгэлийн байгууллагад бүртгүүлэх, холбогдох эрх бүхий байгууллагад хүргүүлэхийг Гүйцэтгэх захирал /М.Эрдэнэсүх/-д даалгасугай.
6. Компанийн үйл ажиллагааг идэвхжүүлж ажиллахыг төлөөлөн удирдах зөвлөлд даалгасугай.

Хэлэлцэх асуудал дууссан тул хурал 14 цаг 30 минутад өндөрлөв.

ХУРЛЫН ДАРГА:

ТЭМДЭГЛЭЛ ХӨТӨЛСӨН :



С.БОЛОР

Б.АНХБАЯР